



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 156

Улаанбаатар хот

Мэргэжлийн үйл ажиллагаа  
эрхлэх зөвшөөрөл хүчингүй болгох  
тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Монгол улсын Дээд шүүхийн 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 434 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 68 дугаар тушаалын 6.7.2-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний их эмч Харуул овогт Цэрэндэндэвийн Оюунгэрэл, хүний их эмч Одгоо овогт Дашдаваагийн Батзаяа нарын эмчлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 жил, сувилагч Буянт овогт Дэмчигийн Ганчимэгийн сувилах мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар энэхүү тушаал гарсан өдрөөс эхлэн тус тус хүчингүй болгосугай.
2. Ц.Оюунгэрэл, Д.Батзаяа нарын эмчлэх, Д.Ганчимэгийн сувилах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон талаар эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн санд бүртгэн, нийтэд мэдээлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080542